



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/378

Эрдэнэт

### Хөрөнгө гаргах тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/а/, 29.1.5/а/, 29.2, Засгийн газрын 2001 оны 288 дугаар тогтоол, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны XXIII ээлжит бус хуралдааны I тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн бодлогын хэлтсийн Ажлын хэсгийн санал, хурлын шийдвэрийн дагуу сульдаатай, тэжээлийн доройтолтой, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 0-5 насны 150 хүүхдийг чийрэгжүүлэн эмчлэх арга хэмжээний зардлыг хавсралтаар баталж, “Уян чагнуур”ХХК-тай 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдрөөс хамтран ажиллах гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2.Шаардагдах зардал 15000000 /Арван таван сая/ төгрөгийг “Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, улирлын чанартай гэр сувилал ажиллуулах” зардлаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/, Эрүүл мэндийн газар /н.Баттүвшин/, Мэргэжлийн хяналтын газар /н.Жигдэнгомбо/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны  
 06 дугаар сарын 29-ний өдрийн  
 А/378 дугаар захирамжийн хавсралт

**“СУУРЬ ӨВЧТЭЙ, СУЛЬДААТАЙ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ  
 ХҮҮХДИЙН ЗУНЫ СУВИЛАЛ” ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын нэр	Нэг хүүхэд /10 хоног/	Нэг ээлж /10 хоног 25 хүүхэд/	Нийт 6 ээлж /150 хүүхэд/
1.	Эмчилгээний хоолны зардал/ хүүхэд/	60 000	1500 000	9 000 000
2.	Ээжийн хоол	30 000	750 000	4 500 000
3.	Эмчилгээ, сувилгааны материалын зардал	4200	105 000	630 000
4.	Хүүхдүүдийг хүргэх, буцаах унааны зардал		50 000	300 000
5.	Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, хүүхэд бүрт эмчилгээ сувилгааны карт нээх	500	12 500	75 000
6.	Бусад/ хог хаягдал, эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, ариутгалын бодис, түлээний мод /		75 000	450 000
	Бүгд зардал	94700	2 492 000	14 955 000
7	Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах шатахууны зардал			45 000
	Нийт		15 000 000	